



**ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ АВЛИГАТАЙ  
ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
1.	Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	1.1.Төрийн албаны болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСҮМ)-ийг үндэслэн албан тушаалд томилно.	Жилдээ	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна.
		1.2.Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгоно.		Нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод нээлттэй болсон байна.
		1.3.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулна.		Ажлын байранд тавигдах нийтлэг шаардлагыг батлуулсан байна.
2.	Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтыг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	1.4.Албан тушаалтанд тавигдах ёс зүй мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилно.	Жилдээ	Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан иргэнийг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж томилсон байх.
		1.5.Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт зохион байгуулна.		Төрийн албаны нөөц нэмэгдсэн байх

3.	Олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга, хэлбэрийг шинэчлэн тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох	1.6.Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын хэрэгжилтийг хангана.		Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэн зөв, шударгаар үнэлсэн байх.
4.	Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоодын хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	1.7.Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг мэдээллийн олон эх үүсвэрээр хүлээн авч шийдвэрлэнэ.	Жилдээ	Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн зөвлөл, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан байна.
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
5.	Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	2.1 Иргэн аж ахуйн нэгж байгууллагад үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал <a href="http://www.emongolia.mn">www.emongolia.mn</a> системд холбоно.		Төрийн үйлчилгээг гэрээс эсвэл ажил дээрээс ямар ч үед авах боломж бүрдүүлсэн байна
6.	Өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх,	2.2.Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулна.	Жилдээ	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулсан байна.
7.	хяналт тавих нэхцөл боломжийг бүрдүүлэх	2.3.Олон нийтийн сүлжээгээр иргэдээс ирүүлж буй нийтийн эрх ашиг зөрчигдэж, эцэслэн шийдвэрлэгдэхгүй байгаа өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлж, иргэнд хариу өгнө.		Хуулийн хугацаанд шийдвэрлэж иргэнд хариу өгсөн байна.
Гурав. Төсөв санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
8.	Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах	3.1.Нийслэлийн 2023 оны төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах ажлыг зохион байгуулна.	4 дүгээр улиралд	Нийслэлийн төсвийн төсөлд санал өгсөн байна.
Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				

9.	Тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1-т заасны дагуу худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явцын мэдээллийг Төрийн цахим худалдан авах ажиллагааны систем, <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> , <a href="http://www.ub-procurement.mn">www.ub-procurement.mn</a> сайтуудад тогтмол ил тод, нээлттэй, шууд татан авч үзэх боломжтой байдлаар байршуулна.	Тухай бүр	Мэдээллийн ид тод байдал хангагдсан байна.
----	--	--	-----------	--

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ДАВААХАТАН

С.БОЛДОО